



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/31

Рашаант сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад
шилжүүлэх болон хаяг шинэчлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Шархүү овогтой Мөнх-Эрдэнийн хүсэлтийн дагуу 4-р багийн Нисэх-15-1517 тоот байршилтай 6706000463 нэгж талбарын дугаартай гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 1228 м² газрын эзэмших эрхийг иргэн Баасан овогтой Дэмбэрэлсамбууд үлдсэн 1 жилийн хугацаатайгаар шилжүүлсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2010 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 94 дугаар захирамжийн 53 дугаар мөрийг хүчингүйд тооцсугай.

3. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал /Б.Ариунжаргал/-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн биелэлтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Т.Отгонцэцэг)-д, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (М.Билэгдэмбэрэл) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ



6706011062

My comp;D;Bichig hereg;A-zaxiramj